

205



Б Н М А У

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

19 9/оны 10 сарын 8/3

№ 350

Улаанбаатар
хот

Улсын үйлдвэрийн газар бай-
гуулах тухай

БНМАУ-ын Аж ахуйн нэгжийн тухай хуулийг үндэслэн Улаан-
баатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Троллейбусны комбинатыг татан буулгаж "Шахилгаан
тээвэр" компани /УҮГ/ байгуулсугай.

2. "Шахилгаан тээвэр" компанийн дүрмийн санг 55,6 сая
төгрөгөөр тогтоож компанийн дүрмийг хавсралтаар батал-
сугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

[Signature]

Л.ЭНЭЭШИ

[Signature]

Ц.БОЛДСАЙХАН

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ 1991 ОНЫ 12-Р САРЫН 23 НЫ
ӨДРИЙН 359 ТООТ ТОГТООЛЫН ХАВСРАЛТ

УЛААНБААТАР ХОТЫН "ЦАХИЛГААН ТЭЭВЭР"
КОМПАНИЙ /УУГ/ ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

1. Улаанбаатар хотын "Цахилгаан тээвэр" Компани нь: Аж ахуйн нэгжийн хуулийн 5 бүлэгт зааснаар үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах аж ахуйн нэгж бөгөөд улсын үйлдвэрийн газар мөн.

2. Байгууллагын үйл ажиллагааны зорилго нь: Нийслэлийн зорчигч тээврийн тодорхой хэсэг, чиглэлийн зорчигчдод үйлчилж үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангахад оршино.

3. Тус компани нь: банкинд харилцах данстай, төр аж ахуйн аливаа нэгжтэй гэрээ, хэлэлцээр байгуулах, өөрийн нэрийн өмнөөс үйлдвэрлэл, үйлчилгээ тогтвортой эрхэлж үйл ажиллагаатайгаа холбогдон үүсэх үүргийг эд хөрөнгөөрөө хариуцах этгээд байна.

4. "Цахилгаан тээвэр" компани нь улсын бүртгэлд бүртгүүлж, Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байрлах бөгөөд тогтоосон журмаар хийсэн байгууллагын тэмдэг, тухаалы, албан бичгийн нүүр, хуудастай байж үндсэн үйл ажиллагааны тайлан, тэнцэл гаргана.

Хоёр. Эд хөрөнгө

1. "Цахилгаан тээвэр"-ийн компанийн эд хөрөнгө нь үндсэн сан, эргэлтийн хөрөнгө, санхүүгийн бусад нөөцөөс бүрдэнэ. Эд хөрөнгөө БНМАУ-ын хууль тогтоомж болон дүрэмдээ нийцүүлэн үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу эзэмшин, ашиглаж захирал зарцуулна.

2. Байгууллагын хөрөнгийг бүрдүүлэх эх үүсвэр нь улсын төсвийн хөрөнгө, бүх төрлийн эзэл, үйлдвэрлэл, үйлчилгээний болон бусад үйл ажиллагаанаас олсон орлого, хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр байна.

3. Тус компанийн эд мөргөнгийг хайр гамгүй эзэмшсэн зүй бусаар ашигласан, эвдэлж гэмтээсэн буюу бусад хэлбэрээр хохирол учруулсан гэм буруутай этгээдэд хууль тогтоомжинд заасаны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Турав. Үйлдвэрлэл үйлчилгээний үйл ажиллагаа

1. Тус байгууллага нь үйлдвэрлэл үйлчилгээний үйл ажиллагааг энэ дүрмийн ерөнхий зүйлийн хоёрт заасаны дагуу ажил үйлчилгээг оновчтой зохион байгуулан шугамын үйлчилгээний чанар соёлыг дээшлүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

2. Өмчлөгчийн эрх олгосон байгууллагын өмнө хүлээсэн түргээ ханган биелүүлэхийн тулд нийт ажилтнууд эзэмшсэн мэргэжил дадлагадаа тулгуурлан Зах зээлийн эдийн засгийн үеийн амьдралд суралцах, хариуцсан үйлдвэрлэл, үйлчилгээнийхээ ажилд хувийн мэдлэг чадварын хирээр өрсөлдөх, тогтвор суурьшилтай, сахилга хариуцлагатай хөдөлмөрлөх явдал мөн.

3. Зорчилт тээврийн ажил үйлчилгээнд хөдөлмөрийн өндөр амжилт бүтээл гаргасан ажилтаныг төр, засгийн болон холбогдох бусад байгууллагын шагнал урамшуулалаар шагнуулах, үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байгаа байгаль орчинг хамгаалах, ажиллагчдын хөдөлмөрлөх нөхцөл боломжийг сайжруулах эрүүл мэндийг хамгаалах зэрэгтэй холбогдсон арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Дөрөв. Байгууллагын эрх

1. Тус компани нь: Өөрийн үйлдвэрлэл үйл ажиллагаатай холбогдох дараах эрхийг эдлэнэ.

а/. Төр, засгийн болон харъяалах дээд байгууллагад байгууллагын ажил үйлчилгээний талаар төсөл, санал боловсруулж оруулах, хариу авах, шийдвэрлүүлэх.

б/. Троллейбусны техник ашиглалтын дүрэм болон тээвэр ашиглалтын талаар дээд байгууллагаас гаргасан дүрэм, захирамж зөрчсөн байгууллага, иргэдийн биелүүлэхийг шаардах, шалгаж хянах, хууль тогтоомжийн дагуу зохих арга хэмжээ оногдуулах

в/. БНМАУ-ын Аж ахуйн нэгж, Хөдөлмөрийн болон бусад хууль тогтоомжинд зааснаар Аж ахуйн аливаа нэгж, байгууллагын ажилтнуудтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах.

Тав. Удирдлага зохион байгуулалт

1. Компанийн захиралыг шууд харьяалах дээд байгууллага Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх Захиргаа гэрээний үндсэн дээр томилон ажиллуулна.

2. Компанийн захирал нь байгууллагын үйлдвэрлэл, үйл ажиллагааны бүх ажлыг удирдан зохион байгуулж үр дүнг хариуцана.

3. Захирал нь дээд шатны байгууллага болон бусад аж ахуйн аливаа нэгжтэй компанийг төлөөлөн харилцах эрх эдлэж, үүрэг хариуцлага хүлээж, тэдгээртэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

4. Байгууллагын орон тоо зохион байгуулалт, дүрам, зааварыг өөрчлөх, эд хөрөнгийг зарцуулах, ажилтаныг ажилд авах, хадах, цалин хөлсийг тогтоох, ~~шаарцаж~~, тэтгэмж, тусламж олгох, сахилгын шийтгэл хүлээлгэх зэрэгт Захиргааны зөвлөлийг ажилдуулж тэдний саналыг харгалзах бөгөөд Аж ахуйн нэгжийн, Хөдөлмөрийн, бусад хууль тогтоомжоор олгогдсон эрхийн хүрээнд шийдвэр нь захиралын тушаалаар хэрэгжинэ.

5. "Цахилгаан тээвэр" компани /УУГ/ дэргэдэх үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтын гэрээ байгуулж гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллана.

**Бургаа. Үйл ажиллагааг нь зогсоох, өөрчлөн
байгуулах, татан буулгах**

1. "Цахилгаан тээвэр" компанийг /УУГ/ үйл ажиллагааг нь зогсоох, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Улаанбаатар хотын Ардын хурлын гүйцэтгэх Захиргаа шийдвэрлэнэ.